

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ГҮЙЦЭТГЭЛ
САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

ӨВТ

2022.12.30

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, зөвлөмж	Зөвлөмжийн заалт	Хэрэгжилт	Хувь
				Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
1.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цахим мэдээллийн сангийн бүртгэл хяналтыг сайжруулах	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цахим мэдээллийн сан бүрдүүлж, цахим мэдээллийн санд байгаа шийдвэрийг он оноор нь хяналтад авч, хяналтаас хасагдсан байдал, тухайн шийдвэрийн хэрэгжилт тогтмолжсон эсэх, хүчингүй болсон эсэхийг хянадаг болсон. Цахим мэдээллийн сангаас 2022 онд нийт 115 шийдвэрийн 205 заалтыг хяналтад авч, хэрэгжүүлж ажилласан.	100%
2.	Төсөвт байгууллагуудад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл хяналтыг тогтмолжуулах	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.2	Ерөнхий боловсролын сургууль, 1, 2 дугаар цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвд хэрэгжих хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн бүртгэлийг тогтмолжуулж, хагас, бүтэн жилийн байдлаар бүртгэл хийгдсэн байдлыг хянаж, зөвлөгөө өгч, биелэлтийг гаргуулан авсан. Байгууллагууд тогтоол шийдвэрээ бүртгэлийн дэвтэр болон цахим хэлбэрээр бүртгэж хэвшсэн. Тайлант хугацаанд сумын Засаг даргын 245 захирамж, ЗДТГ-ын даргын 58 тушаал, нийт 303 шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, баталгаажуулсан. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 88 тушаал, Эрүүл мэндийн төвийн даргын 54 тушаалын хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөгөө өгч зөрчлийг арилгуулсан. Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга наарт зайлшгүй шаардлагатай хууль, тогтоомжуудыг хэвлэж, сан бүрдүүлсэн.	100%

				
3.	Хуулиудыг хяналтад авах, бүртгэлжүүлэх, хэрэгжилтийг тооцох асуудалд өнхаарах. Энэ чиглэлээр бусад байгууллага, албан хаагчдыг арга зүйгээр хангаж ажиллах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.3	<p>Өмнөх жилүүдэд хуулийг хяналтад авч хэрэгжилтийн биелэлтийг дүгнэж гаргаж байгаагүй. Энэ жил буюу 2022 онд Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэлд Төрийн хэмнэлтийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/, Татварын ерөнхий хууль, Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ нийт 8 хуулийн 25 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг тооцож ажилласан. Хуулийн хэрэгжилт 95,2% биелсэн.</p> <p>Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн мэргэжилтэн 2022 оны 06 дугаар сар, 11 дүгээр сард Засаг даргын Тамгын газар, бусад төрийн байгууллагуудын албан хаагчдад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, тайлан гаргах арга зүйн зөвлөгөө болон аймгийн Засаг даргын 2021 оны а/342 дугаар захирамжаар батлагдсан журмыг танилцуулах сургалт зохион байгуулж, мэдээлэл өгсөн.</p>	100%

				
4.	Zасгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн суманд хамаарал бүхий зорилт арга хэмжээг бүрэн хяналтад авч хэрэгжүүлэх. (Тухайлбал нийтийн биеийн тамир (2.2), боловсрол (2.3), Хөдөлмөр нийгмийн хамгаалал (2.5), Аялал жуулчлал (3.4), Амар тайван аюулгүй байдал (4.3), Ногоон хөгжил (5.1) зэрэг зорилтуудаас хяналтад огт авагдаагүй байна)	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.5	Нийтийн биеийн тамир, боловсрол, хөдөлмөр нийгмийн хамгаалал, аялал жуулчлал, амар тайван аюулгүй байдал, ногоон хөгжил зэрэг зорилтуудаас хяналтад авч аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, сумын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийт 41 ажил төлөвлөж гүйцэтгэл 93,4 хувьтай биелсэн.	100%
5.	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтооюур батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу зорилт, арга хэмжээний томьёололтой уялдуулж,	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.6	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт маягтаар аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцож тайлагнасан. Зорилт, арга хэмжээний томьёолоходоо хүрэх түвшинг тодорхойж, тоон үзүүлэлтээр тайлагнахад анхаарч ажилласан.	100%

	товч тодорхой, тоон үзүүлэлтээр илэрхийлэх			
6.	Сумын жилийн хөгжлийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр аль болох цөөн тооны хэрэгжих боломжтой төсөл, арга хэмжээг төлөвлөх.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 3.7	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс 405.0 сая төгрөг, малын тоо толгойн албан татвараас 247.7 сая төгрөг буюу нийт 652.7 сая төгрөгийн 33 хөрөнгө оруулагт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулснаас 31 төрлийн 384.0 сая төгрөгний ажил хэрэгжүүлсэн.	70%
Хоёр. Байгууллагын чиг үүрэгийн үзүүлэлт				
7.	Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гэрээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тоон бэлэн чанарын шалгуурыг хэрхэн хангасан тухай үр дүнд тулгуурлан тайлагнах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4.1	Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж биелэлтийг тооцсон. Тайланг гаргахдаа тоон болон чанарын шалгуурыг хэрхэн хангаж байгааг харьцуулж үр дүнд тулгуурлан тайлагнасан.	100%
8.	Аймгийн Засаг даргын 2021 оны 7 дугаар сарын 6-ны едрийн А/342 дугаар захирамжаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэжжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ, үнэлгээ хийх журам"-ын 4 дүгээр хавсралтын дагуу Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нэхцэл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сард гарган батлуулж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сард бодитой тайлагнаж гаргасан. Дэлгэрэнгүй тайланг хавсралтаар хүргүүлэв.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4.2	Tөрийн албан хаагчийн сургалт, ажиллах нэхцэл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сард гарган батлуулж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сард бодитой тайлагнаж гаргасан. Дэлгэрэнгүй тайланг хавсралтаар хүргүүлэв.	100%
9.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд - Бодлогын барийт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стратеги төлөвлөгөөнд тусгайдсан ижил	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4.3	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стратеги төлөвлөгөөнд тусгайдсан ижил нэршилтэй, ижил утгатай,	

<p>нэршилтэй, ижил утгатай, бие биеэ агуулсан утгатай зорилт, арга хэмжээг нэгтгэж, нэг арга хэмжээ болгон тодорхойлох;</p> <p>- Арга хэмжээний гол үр дүнг харуулсан 1-2 шалгуур үзүүлэлт сонгох, шаардлагатай тохиолдолд чанарын шалгуур үзүүлэлт ашиглэх боломжтой ч аль болох үр дүнд сууринсан шалгуур үзүүлэлт сонгох;</p> <p>-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хугацааг жилээр бус улирлаар төлөвлөсөн байх.</p> <p>-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд (тамгын газрын) бодлого зохицуулалтын хүрээний гол гол арга хэмжээний төлөвлөлтүүдийг хийдэг байх (сумын жилийн хөгжлийн төлөвлөгөө болон албан хаагч тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нарийвчилсан арга хэмжээнүүд орж байгаа учраас үйл ажиллагаа нэг бүрийг тусгах шаардлагагүй)</p> <p>-Төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт, төлөвлөлтөд хяналт тавих. Арга хэмжээг оновчгүй тодорхойлсон, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байх шаардлагыг хангагүй, суурь түвшин тавигдаагүй, зорилтот түвшинг ойлгомжгүй тодорхойлсон, үнэлгээг буруу томьёолсон, үнэлгээний хүснэгтийг буруу ашигласан зэрэг дутагдлыг дахин гаргахгүй байх.</p>	<p>бие биеэ агуулсан утгатай зорилт, арга хэмжээг нэгтгэж, нэг арга хэмжээ болгосон.</p> <p>Арга хэмжээний гол үр дүнг харуулсан 1-2 шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон.</p> <p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хугацааг сар, улирлаар төлөвлөсөн.</p> <p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлого зохицуулалтын хүрээний гол гол ажил, арга хэмжээг төлөвлөн оруулж баталсан.</p> <p>Төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт, төлөвлөлтөд хяналт тавьж, арга хэмжээг оновчтой тодорхойлж, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байх шаардлагыг хангулсан. Суурь түвшин, зорилтот түвшинг тодорхойлж, үнэлгээг аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захирагааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 6.3.2, 6.3.3 дахь заалтын дагуу үнэлсэн.</p>	<p>100%</p>
---	---	-------------

	-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хувьд стратегийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээ гэж задарч томъёолдогдсон байгааг анхаарах			
10.	Сум хөгжүүлэх сангийн зээлийг гэрээний хугацаа дууссан 10 иргэн, хугацаа хэтрэлттэй 6 иргэний нийт 36,000,000 төгрөгний үндсэн зээл болон зээлийн хүүгийн авлагыг төлүүлэх.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 4.4	Zасаг даргын Тамгын газар сум хөгжүүлэх сангийн зээлийн хугацаа дууссан 5 иргэнийг Хархорин сумын сум дундын Прокурорын газарт шилжүүлэн зээл төлүүлэхээр хугацаа тохирч хамтран ажиллаж байна. Гэрээний хугацаа дууссан болон явцын хугацаа хэтрэлт 2021 онд 22,7 хувьтай байсаныг 18,8 хувьд хүргэж бууруулсан. Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд 20 хувьд хүргэхээр заасан. Гэрээний биелэлт 100 хувь.	70%
Гурав. Байгууллагын нээлттэй байдал				
11.	Сумын цахим хуудсанд дараах мэдээллийг ил тод болгох. <ul style="list-style-type: none"> бодлогын баримт бичгүүдийг вэб сайтад нийтлэх <ul style="list-style-type: none"> Төрийн байгууллагуудад ажиллаж буй нээлттэй утасны дугаарыг нэгтгэж ил тод мэдээлэх <ul style="list-style-type: none"> Өргөдөл, гомдлыг цахимаар хүлээж авах өгөгдлийг вэб сайтдаа бий болгох <ul style="list-style-type: none"> Олон нийтээс санал асуулга авах өгөгдлийг вэб сайтдаа бүрдүүлэх <ul style="list-style-type: none"> Сул орон тооны зарыг тогтмол мэдээлэх <ul style="list-style-type: none"> Сумын эдийн засаг нийгмийн өнөөгийн байдал, төрийн албан хаагчдын утасны дугаарыг тухай бүр шинэчлэх <ul style="list-style-type: none"> Төсөвт байгууллага тус бүрт ил тод байдлыг хангах цэс нээж өгөх <ul style="list-style-type: none"> Өргөдөл гомдлын мэдээллийн шийдвэрлэлт, холбогдох журмыг мэдээлэх 	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5.1	http://bat-ulzii.ov.gov.mn/ вэб сайгад дараах мэдээллүүдийг ил тод мэдээлсэн. <ul style="list-style-type: none"> Бодлогын баримт бичгүүд Албан хаагчдын утасны дугаар Өргөдөл, гомдлыг цахимаар хүлээж авах өгөгдөл Олон нийтээс санал асуулга авах өгөгдөл Сул орон тооны мэдээлэл, зар Сумын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал Төсөвт байгууллага тус бүрд ил тод байдлын цэс Өргөдөл гомдлын мэдээллийн шийдвэрлэлт, холбогдох журам Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн утасны дугаарийг тус тус байршуулсан. <p>Сошиал сүлжээнд төрийн байгууллага бүр өөрийн албан ёсны хаягаас мэдээлэл нийтэлдэг болсон.</p> <p>Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, bat-ulzii.ov.gov.mn вэб сайтын хөтлөлтийг сайжруулж, мэдээ, мэдээллийг шинэчлэн, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан. Вэб сайтад тендерийн урилга, үйл ажиллагааны мэдээлэл, тогтоол, шийдвэрүүдийг байршуулсан. Мөн Засаг даргын Тамгын газар нь гадна талбайдаа лэд дэлгэц сууриллуулж, Засаг</p>	100%

	<ul style="list-style-type: none"> Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн утасны дугаарыг нийтлэх Сошиал сүлжээнд төрийн байгууллага бүр өөрийн албан ёсны хаягнаас мэдээлэл нийтлэх /Албан хаагчид хувийн хаягнаас төрийн мэдээлэл нийтлэхгүй байх/ <ul style="list-style-type: none"> http://bat-ulzii.ov.gov.mn/ вэб сайтыг олон нийтэд сурталчлах Сум, орон нутгийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг сонин, сэтгүүл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх Сумын цаг үеийн ажлыг вэб сайтдаа нийтлэх 		<p>даргын Тамгын газар болон бусад төрийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, шторк, зар</p>  <p>сурталчилгаа, хууль тогтоомжийн мэдээллийг дэлгэцээр дамжуулан иргэдэд түгээн ажилласан.</p>	
12.	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр өөрсдийн нөөц бололцоог ашиглаж шторк, видео бэлтгэж сүмын албан ёсны вэб сайтад тусгай цэс үүсгэн тогтмол байрлуулах. Нэлөөллийн ажлуудыг санаачлан зохион байгуулж, иргэдийг олноор хамруулах	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5.2	Авлигатай тэмцэх, авлигын эсрэг сумын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулж хэрэгжүүлэн ажилласан. Авлигын эсрэг хуулийг төрийн албан хаагчдад сурталчлан, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуйж, хяналт тавин ажиллаж, БИНХурлуудад улирал тутам мэдээлж, 250 ширхэг гарын авлага бэлтгэн иргэдэд тарааж, байгууллагын санал хүсэлтийн хайрцаар иргэдээс өдөр тутам мэдээлэл авч ажиллаж байна. 2022 онд авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	100%
13.	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг иргэдээс авч хэвших	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5.3	Сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр багийн иргэдийн Нийтийн хурлын үеэр иргэдээс тогтмол авдаг болсон. Мөн Засаг даргын Тамгын газрын Нэг цэгийн үйлчилгээний төвийн Эрх зүйн хөтчийн буланд санал хүсэлтийн хайрцааг байнга ажиллуулж сэтгэл ханамжийн судалгааг авч хэвшсэн. 2022 онд сэтгэл ханамжийн судалгааг 400-аад иргэнээс авч дүгнэлт хийж, бодлого	100%

			шийдвэртээ тусган төрийн үйлчилгээг улам сайжруулахад анхаарч ажиллаж байна.	
14.	Худалдан авах ажиллагааны цэсийг ажиллагаанд оруулж, жилийн төлөвлөгөө, тайлан, аудитын тайлан, тендерийн урилгыг нийтэлж, холбогдох линкийг холбох	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5.4	http://bat-ulzii.ov.gov.mn/ вэб сайтын худалдан авах ажиллагааны цэсийг холбогдох линктэй холбож, мэдээллийг ил тод болгосон.	100%
15.	Шилэн дансны сайтад төрийн байгууллагууд хугацаандаа мэдээллээ бүрэн оруулах, анхаарч ажиллах.	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5.5	2022 онд Шилэн дансанд төрийн бүх байгууллагууд мэдээллээ бүрэн оруулж хугацаа хоцроосон болон мэдээлэл дутуу оруулсан байгууллага байхгүй. 	100%
16.	Засаг даргын Тамгын газарт 2021 онд хугацаатай бичиг 63 ирснийг хяналтын карт нээгээгүй, бүртгэлийн дэвтэр дээр хариу өгөх хугацааг тэмдэглээгүй, шийдвэрлэлтийн байдал дээр тайлбарыг буруу бичсэн. Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл 488 ирснийг хяналтын карт нээгээгүй, бүртгээгүй зэрэг алдаа дутагдлыг даруй засаж сайжруулах	Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн 5.6	Засаг даргын Тамгын газарт 2021 онд ирсэн 63 хугацаатай бичигт хяналтын карт нээж, бүртгэлийн дэвтэр дээр хариу өгөх хугацааг тэмдэглэж, шийдвэрлэлтийн байдал дээр тайлбарыг зөв бичсэн. Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн 488 өргөдөл хяналтын карт нээж, бүртгэсэн. Алдаа дутагдлыг засаж сайжруулсан.	100%
Биелэлтийн нэгдсэн үнэлгээ				96,2%

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

ХЭРЭГКИЛТ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

